



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2014 оны 05 сарын 16 өдөр

Дугаар 166

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.23, Эрүүл мэнд, Боловсрол, шинжлэх ухааны сайдын хамтарсан 2013 оны 491/А/472 дугаар тушаалын 2.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ.нь:

1. Эмчлэх үйл ажиллагаа эрхлэх хоёр жилийн зөвшөөрөлтэй хүний их эмчийн ажиллан суралцах журмыг хавсралтаар баталсугай.

2. Тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Эрүүл мэндийн хөгжлийн төв (Ч.Бат-Эрдэнэ), аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга, эрүүл мэндийн байгууллагын дарга нарт үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн яамны дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлийн дарга /А.Эрдэнэтуяа/-д даалгасугай.

САЙД



Н.УДВАЛ

Эрүүл мэндийн сайдын
2014 оны 05 сарын 16 өдрийн
16.6 дугаар тушаалын хавсралт

ЭМЧЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ХОЁР ЖИЛИЙН ЗӨВШӨӨРӨЛТЭЙ ХҮНИЙ ИХ ЭМЧИЙН АЖИЛЛАН СУРАЛЦАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Энэхүү журмын зорилго нь 2 жилийн зөвшөөрөл бүхий хүний их эмч эхний жил өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэгт, хоёр дах жил аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, түргэн тусламжийн төвд ажиллан суралцах (цаашид "сургалт" гэх) харилцааг зохицуулахад оршино.

1.2 Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Төгсөлтийн дараах сургалтын зохицуулалтын хэлтэс нь 2 жилийн зөвшөөрөл бүхий хүний их эмчийг анхдагч болон хоёрдогч шатлалын эмнэлгүүдэд хуваарилан, сургалттай холбоотой үйл ажиллагааг зохион байгуулж тогтмол хяналт тавьж, удирдлага арга зүйгээр ханган ажиллах ажлын алба болно.

1.3 Мэргэжлийн салбар зөвлөлийн гишүүд нь сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, хяналтын хуудас бүхий сургалтын дэвтэр болон ажлын тайлан бичих загварчлал зэргийг боловсруулж, эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлөөр баталгаажуулан, ажлын албанд өгнө.

1.4 Аймаг, нийслэлийн ЭМГ нь өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын болон аймаг дүүргийн нэгдсэн эмнэлэг, түргэн тусламжийн төвд ажиллан суралцах эмч (цаашид "суралцагч" гэх) - ийн захиалгыг ажлын албанд өгөх, суралцагчийг эрүүл мэндийн байгууллагад хуваарилж, сургалтын явцад хяналт тавина.

1.5 Суралцагч нь тухайн хуваарилагдсан аймаг, нийслэлийн ЭМГ болон ажлын албатай гэрээ байгуулна.

Хоёр. Элсэлт ба хуваарилалт

2.1. Аймаг, нийслэлийн ЭМГ нь өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын болон аймаг дүүргийн нэгдсэн эмнэлэг, түргэн тусламжийн төвд суралцах суралцагчийн захиалгыг тухайн оны нэгдүгээр улиралд багтаан ажлын албанд ирүүлнэ.

2.2. Анагаах ухааны боловсрол олгох их, дээд сургуулиуд хүний их эмч мэргэжлээр төгсөх суралцагчийн тоог тухайн оны 4 дүгээр сард багтаан ажлын албанд ирүүлнэ.

2.3. Ажлын алба нь жил бүрийн 5 дугаар сарын эхний долоо хоногт багтаан ажлын байрны захиалгаар үзэсгэлэн яармаг зохион байгуулна.

2.4. Ажлын алба нь анагаах ухааны боловсрол олгох их, дээд сургуулийг хүний их эмчээр төгсөгчдийг бүртгэж, суралцагчийн тухай цахим мэдээллийн сан бүрдүүлж, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн шалгалтыг зохион байгуулна.

2.5. Ажлын алба нь эрүүл мэндийн байгууллагаас ирүүлсэн захиалга болон суралцагчийн санал, хүсэлтийг үндэслэн аймаг, нийслэлийн ЭМГ-т хуваарилна. Хуваарилалтыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний тушаалаар баталгаажуулан, суралцагчдад хяналтын хуудас бүхий сургалтын дэвтэр, томилолт олгоно.

2.6. Аймаг, нийслэлийн ЭМГ нь суралцагчийг өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын болон аймаг, дүүргийн эмнэлэг, түргэн тусламжийн төвд хуваарилна.

2.7. Ажлын алба нь суралцагчийн ЭМГ болон ажлын албатай байгуулах гэрээний загварыг боловсруулж эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаар баталгаажуулна.

Гурав. Зохион байгуулалт

3.1. Өрх, сум тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэгт зохион байгуулагдах сургалтын тухай

- 3.1.1. Өрх, сум тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэгт ажиллаж буй нэг эмч 1-2 суралцагчийн сургалтыг удирдана.
- 3.1.2. Суралцагч эхний жилд буюу өрх, сум тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэгт суралцах хугацаандаа сургалтын хөтөлбөрийн дагуу сард 1,5 багц цаг нийт 16,5 багц цаг цуглуулах ба сургалт удирдсан эмч өдөр бүр хяналтын хуудсын дагуу үнэлгээ хийн сарын эцэст сургалтын дэвтэрт тэмдэглэн, байгууллагын даргаар баталгаажуулна.
- 3.1.3. Сар бүр тогтмол хугацаанд сургалтын дэвтрийн үнэлгээг нь үндэслэн суралцагчид Засгийн газрын тогтоолоор ТҮЭМ-3.1 цалин олгоно.
- 3.1.4. Сургалт удирдсан эмч түр хугацаагаар эзгүй үед суралцагч нь аймаг, дүүргийн мэргэшлийн эмчээс зөвлөгөө авна.
- 3.1.5. Суралцагч нь өрх, сум тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэгт суралцсан талаархи жилийн тайланг загварчлалын дагуу гарган, эрүүл мэндийн байгууллагын даргаар баталгаажуулан аймаг, нийслэлийн ЭМГ-т 4 дүгээр сард багтаан өгнө.
- 3.1.6. Аймаг, нийслэлийн ЭМГ нь сургалтын явцад хяналт хийсэн тайлан болон суралцагчийн тайланг ажлын албанд 5 дугаар сард өгнө.

3.2. Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, түргэн тусламжийн төвд зохион байгуулагдах сургалтын тухай

- 3.2.1. Аймаг, нийслэлийн ЭМГ нь суралцагчийг 2 дахь жилд нь аймаг дүүргийн нэгдсэн эмнэлэгт хуваарилна.
- 3.2.2. Аймаг, нийслэлийн ЭМГ нь суралцагчийг дотор, хүүхэд, эх барих эмэгтэйчүүд мэс засал, яаралтай тусламжийн тасаг, кабинет болон түргэн тусламжийн төвд тойролт хийх хуваарь гарган хуваарилна.
- 3.2.3. Тойролт бүрд тасгийн нэг эмч нь 1-2 суралцагчийн сургалтыг удирдана.
- 3.2.4. Суралцагч нь 2 дах жилдээ аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэгт суралцахдаа сургалтын хөтөлбөрийн тойролт хийн тасаг, кабинет болон түргэн тусламжийн төвд хуваарилагдан сард 2,5 багц цаг буюу тойролт бүрд 5,5 багц цаг нийт 27,5 багц цаг цуглуулж, тойролт удирдсан эмч сургалтын дэвтэрт тэмдэглэн, байгууллагын даргаар баталгаажуулна.
- 3.2.5. Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлгийн тойролт бүрд сургалт удирдсан эмч нь өдөр бүр хяналтын хуудсын дагуу үнэлгээ хийн тойролтын эцэст сургалт удирдсан эмч сургалтын дэвтэрт тэмдэглэн, байгууллагын дарга баталгаажуулна.
- 3.2.6. Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлгийн дарга нь суралцагчийн ажлын тайланг үндэслэн сар бүр суралцагчид засгийн газрын тогтоолоор ТҮЭМ-3.1 цалин олгоно.
- 3.2.7. Тойролт бүрт суралцагч загварчлалын дагуу тайлан гаргах бөгөөд жилийн нэгдсэн тайланг эрүүл мэндийн байгууллагын даргаар баталгаажуулан аймаг, нийслэлийн ЭМГ-т 4 дүгээр сард багтаан өгнө.

3.2.8. Аймаг, нийслэлийн ЭМГ нь сургалтын явцад хяналт хийсэн тайлан болон суралцагчийн тайланг ажлын албанд 5 дугаар сард багтаан өгнө.

Дөрөв. Шилжилт хөдөлгөөн

4.1 Суралцагч хүндэтгэх шалтгаанаар чөлөө авах нь жилд нийт 3 долоо хоногоос хэтрэхгүй байна.

4.2 Суралцагч хүндэтгэх шалтгаанаар 3 долоо хоногоос дээш хугацаагаар сургалтаас завсардсан тохиолдолд ажлын алба жилийн чөлөө олгоно.

4.3 Ажлын алба нь суралцагч 2-оос дээш удаа сургалтаас жилийн чөлөө авсан тохиолдолд сургалтаас бүр мөсөн чөлөөлнө.

Тав. Төгсөлт

5.1 Ажлын алба нь 44 багц цагийг бүрдүүлсэн хяналтын хуудас бүхий сургалтын дэвтэр, эрүүл мэндийн байгууллагын даргаар баталгаажуулсан ажлын тайлан, эрүүл мэндийн байгууллагатай байгуулсан гэрээ, нийгмийн даатгалын дэвтэр зэргийг үндэслэн 5 жилийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг Эрүүл мэндийн сайдын тушаалаар баталгаажуулан шууд олгоно.

5.2 5 жилийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авсан төгсөгч нь цаашид ерөнхий мэргэжлийн эмчээр үргэлжлүүлэн ажиллаж болно.

5.3 Төгсөгч нь үндсэн мэргэшлийн сургалтад үргэлжлүүлэн суралцах бол төгсөлтийн дараах мэргэжлийн сургалтын элсэлт, төгсөлтийн журмын дагуу сургалтад элсэнэ.

Зургаа.Бусад

6.1. Ажлын алба нь анхан болон хоёр дах шатны эмнэлгийн сургалт удирдах эмч нарыг сурган заах арга зүйн ур чадварын сургалтад нэгдсэн журмаар хамруулах ажлыг зохион байгуулна.

6.2. Суралцагчийг эмч, эмнэлгийн мэргэжилтний баримтлах ёс зүйн харилцаа хандлагад суралцуулж, ёс зүйн алдаа гаргахгүй ажиллахад сургалт удирдаж буй эмч дэмжлэг үзүүлж, хяналт тавина

6.3. Өрх, сум тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэгт сургалт удирдсан эмч тухайн жилийн эцэст тайлан бичиж, байгууллагын даргаар баталгаажуулан ажлын албанд хүргүүлнэ.

6.4. Сургалт удирдсан эмчийн ажлын тайланг үндэслэн 1 суралцагчийг жилийн турш удирдсан бол 3 багц цаг, нэг тойролт удирдсан бол 0,6 багц цаг олгоно.

6.5. Монгол улсын Засгийн газрын 150 дугаар тогтоолоор 2012 оны 5 дугаар сард батлагдсан “Эрүүл мэндийн ажилтанд нэмэгдэл, мөнгөн урамшуулал олгох” журмын дагуу нийтлэг болон тусгай шалгуур үзүүлэлтээр дүгнэсэн ажлын үр дүнгийн үнэлгээнд сургалт удирдсан эмчид 10-30 оноо нэмж урамшуулна.